

**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ДОРЖСҮРЭНГИЙН ДОЛГОРСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /хүрээгүй бол тайлбар/	Эхэлсэн, дууссан хугацаа	хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжинэ							
Зорилт 4 Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.							
1	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	Төсвийн хэмнэлт, хувиар, Үүссэн өглөг, авлага төгрөгөөр,	2023 онд 85.0 тэрбум төгрөг батлагдсанаас 2023 оны 1 дүгээр улиралд 21.6 тэрбум төгрөг батлагдаж, төсвийн гүйцэтгэлээр 12.5 тэрбум төгрөгийг зарцуулсан.	Тайлант оны батлагдсан төсвийг оновчтой хуваарилан, зарцуулалтад хяналт тавьж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг бүрэн хангаж ажилласан байна	Гаалийн байгууллагын 2024 оны төсвийн төслийн саналд 141.2 тэрбум төгрөгийн саналыг тусган Сангийн яаманд хүргүүлснээс урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 137.5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 62%-иар буюу 52.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Гаалийн байгууллагын батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилахдаа 2023 оны төсвийн гүйцэтгэл, ажиллаж буй орон тоо, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах бусад хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилж, Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй байх чиглэлээр төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ажиллаа. Тайлант хугацаанд харьяа газар, хороодоос ирүүлсэн үндсэн болон нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлт, АО-с төлөх НДШ-ийн зардлууд, төрийн тусгай албан хаагчийн сэлгэн ажилуулалт болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн тоотой уялдуулан үр дүнгийн урамшууллын зардал, боомтуудын бүтээн	2024.01.01 – 12.31	100

				байгуулалттай холбоотой байр ашиглалтын зардлууд, автомашинуудын урсгал засвар, тээвэр, шатахууны зардал, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсэн албан хаагч болон нас барсан албан хаагчийн ар гэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, бичиг хэрэг, улсын мэдээллийн маягт хэвлэх зардал, шуудан холбоо, багаж техник хэрэгсэл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын үйлчилгээ, газрын төлбөр, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах ажилчдын орон сууц, хилийн боомтуудын урсгал засвар, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудын нийт 220 саналыг тооцоо, судалгааг үндэслэн төсвийн хуваарьт 11 удаагийн өөрчлөлт оруулж, 106.3 тэрбум төгрөгийг хуваарилан, зарцуулалтад хяналт тавин ажилалаа. Мөн харьяа газар, хороодын туслах үйл ажиллагааны орлогын мэдээг сар бүрийн 1-ний дотор, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ний дотор гаргуулан авч хянан, нэгтгэж Гаалийн байгууллагын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж Сангийн яаманд цаг хугацаанд нь хянуулан ажиллаж байна. Гаалийн байгууллагын 2024 оны нийт батлагдсан төсвөөс 11 сарын байдлаар 114'617.6 сая төгрөгийн урсгал зардлын төлөвлөгөөтэй ажиллаж 96'639.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 17'978.0 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэл хавсаргав. Тайлант оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэл бүрэн санхүүжигдээгүй байгаа тул бодит	
--	--	--	--	--	--

					хэмнэлтийг тооцох боломжгүй байна. (Төсвийн гүйцэтгэлийн мэдээг хавсаргав.)		
2	Байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргах, удирдлагыг мэдээллээр хангасан байдал, аудит хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ҮАГазраас 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Өөрчлөлтгүй санал дүгнэлийн 4 зөвлөмж 1 албан шаардлагын хамт ирүүлсэн.	Байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, Үндэсний аудитын газарт хүргүүлэн хянуулж, Өөрчлөлтгүй санал дүгнэлтийг авсан байна.	Гаалийн ерөнхий газрын харъяа Гаалийн газар хороод, Горхи мэлхий хад амралтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлан тэнцэл, тодруулгуудыг байгууллага бүрээр тойрох хуудсаар баталгаажуулан хоорондын тооцоог нийлэн баталгаажуулж нэгтгэн ажиллалаа. Нийт 20 байгууллага санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлтийг авсан. Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газрын СХОХ, ААҮАлба, харъяа гаалийн газар хороод, Горхи мэлхий хад амралтын газар нь санхүүгийн бүртгэлээ “unicus” программаар хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргасан. Харин Гаалийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээний санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны Э-Тайлангийн программаар нэгтгэн гаргаж Үндэсний аудитын газар хүргүүлсэн. ҮАГазраас гаалийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлтийг 2 зөвлөмж, 1 албан шаардлагын хамт ирүүлсэн. <u>Зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг ханган тайланг заасан хугацаанд буюу 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 01/3317 дугаар албан бичгийн хавсралтаар хүргүүлж ажиллаа. Үүнд:</u> <u>Зөвлөмж 1:</u> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, шилэн дансны хөндлөнгийн мониторинг хийлгэхгүй байх.	2024.01.01 – 12.31	100

					Биелэлт: Авлигатай тэмцэх газрын 2023 оны 01/2912 албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу нийт 5 зорилгын хүрээнд 16 арга хэмжээ бүхий “Гаалийн байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөний 3.2-т “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. Тус журмын 2.1.2.Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал-д олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх гэж заасны дагуу Гаалийн ерөнхий газар болон харьяа 18 гаалийн газар, хороодын “Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал”-д мониторинг хийлгэхээр 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Меркадо ХХК-тай MRCD/ГЕГ/2023 дугаартай судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гаалийн байгууллагын “Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал”-д мониторинг хийж, 6 агуулгын хүрээнд нийт 90 хуудас тайланг ирүүлэн ажилласан. Тайлант онд Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх журмын 2.1.2.Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй		
--	--	--	--	--	--	--	--

				байдал-д хөндлөнгийн мониторинг хийлгэх талаар тусгуулаагүй болно. <u>Зөвлөмж 2:</u> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлж байх. Биелэлт: Санхүү хөрөнгө оруулалтын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “тус онд нийт 375.5 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийн зардлын гүйлгээг өглөгийн дансаар дамжуулан давхар бичилт хийлгүй шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэсэнтэй нийцэхгүй байна.” гэсэн зөвлөмж ирүүлсний дагуу 2024 оны эхний 8 сарын байдлаар гадаад, дотоод албан томилолтын зардалд нийт 174.9 сая төгрөгийн 56 ажил гүйлгээ, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 104.1 сая төгрөгийн 107 ажил гүйлгээ, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 348.5 сая төгрөгийн 177 ажил гүйлгээ, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 81.6 сая төгрөгийн 2 ажил гүйлгээг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу давхар бичилтийн аргаар хөтлөн ажиллаж байна. <u>Албан шаардлага 1:</u> Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан, илэрсэн зөрчлийг арилган давтан гаргахгүй байх чиглэлээр АЛБАН ШААРДЛАГА ирүүлсний дагуу ХШҮДАГ-тай хамтран санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган биелэлтийг ҮАГазарт тайлагнан	
--	--	--	--	---	--

					ажиллаа. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу харьяа газар, хороодын нягтлан бодогч нарыг хамруулсан сургалтыг цахимаар зохион байгуулсан. Тус сургалтыг 2023 оны санхүүгийн тайланд илэрсэн нийтлэг алдаа болох эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ гаргасан, шилэн дансны хуулийн хэрэгжилт сайжруулах чиглэлээр ХШҮДАГ-тай хамтран зохион байгуулсан.		
3	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Өмнөх оны 1 дүгээр улиралд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан цагалбарын дагуу 5 нээлттэй, 15 харьцуулалттай тендерийг цахимаар зарласан байна.	Тайлант хугацаанд төлөвлөсөн худалдан авах ажиллагааг хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулж ажилласан байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд шилжих ангиллаар 15,285.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан. Үүнд: • Гаалийн хяналт бүрдүүлэлтийн барилга /Увс, Улаангом сум/ 785.2 сая төгрөг, • Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/ 14,500.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ батлагдан хэрэгжиж байна. Үүнд: - Гаалийн хяналт шалгалтын “Ухаалаг гарц” иж бүрдэл тоног төхөөрөмж 3,600.0 сая төгрөг, - Гаалийн хяналтын /рентген/ систем-10,900,0 сая төгрөг. Санхүүжилт бүрэн хийгдсэн. Тайлант онд Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр тушаалаар 3,872.7 сая төгрөгийн 4 арга хэмжээний худалдан авах ажиллагаа, 213 дүгээр тушаалаар 3,090.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавих, хэрэгжилтийг хангах, санхүүжүүлэх, тайлагнахыг ГЕГ-т	2024.01.01 – 12.31	100

					үүрэг болгосон. Гаалийн ерөнхий газар тушаалын хэрэгжилтийг бүрэн хангаж худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэгчийн нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээг хүлээн авах, гэрээ дүгнэх, санхүүжилтийг олгох зэрэг ажлыг бүрэн зохион байгуулан ажиллаа. Сангийн сайдын эрх шилжүүлсэн нийт 6'962.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаас нийт 6'821.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 141.3 сая төгрөгийн хэмнэлт үүссэн. Гаалийн байгууллагын урсгал төсвөөр 2024 онд нээлттэй 20, харьцуулалтын аргаар 30 нийт 50 тендер зарлахаар төлөвлөсөн. Үүнээс нээлттэй 20 тендер зарлагдаж, тендер нээх хугацаа болоогүй 2 тендер, Сангийн яаманд гомдол гаргасан хянагдаж байгаа 1 тендер байна. Бүхэлдээ амжилтгүй болсон тендер байхгүй бөгөөд амжилтгүй болсон 3 багц байна. Амжилтгүй болсон 3 багцын 2 нь 3 удаа тендер зарласан боловч оролцогч байхгүй, 1 багц (албаны костюм) нь Сангийн яаманд гомдол гаргаж, бараа үйлдвэрлэх хугацаагүй болсон тул дахин зарлах боломжгүй болсон. Харьцуулалтын аргаар 30 тендер зарлагдаж 100 хувь амжилттай зохион байгуулагдан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, бараа ажил үйлчилгээг хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийг олгох ажлыг зохион байгуулан ажиллаа.	
--	--	--	--	--	---	--

					(Худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй тайланг холбогдох журмын дагуу боловсруулж, заасан хугцаанд нь СЯ-ны холбогдох нэгж болон ГЕГ-ын ЗУГ, ХШУДАГазарт тус тус хүргүүлэн ажиллаа.)		
4	Албан хаагчдын нийтлэг баталгаа цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-Гаалийн улсын байцаагчийн дундаж цалин 229,3970 төгрөгөөр нэмэгдсэн, -Өндөр насны тэтгэвэрт гарсан 7 албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж болгон нийт 176.1 сая төгрөг; Ар гэрийн гачигдал гарсан 25 албан хаагчдад нийт 13.6 сая төгрөгийн буцалтгүй тусламж; Гаалийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан нийт албан хаагчдад үндэсний баяр цагаан сараар хүндэтгэл үзүүлэх зардалд 10.4 сая төгрөг; Төрийн үйлчилгээний 27 албан хаагчид нийт 2.7 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.	Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлсэн байна.	1. Албан хаагчдын унаа, хоолны үнийн хөнгөлөлт нэмэгдүүлсэн: Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээ бүхий Улаанбаатар хотод ажилладаг гаалийн байгууллагын албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын хөнгөлөлт болон Гаалийн байгууллагын нийт албан хаагчдын үдийн хоолны үнийн хөнгөлөлтийг ГЕГ-ын даргын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/172 дугаар тушаалаар тогтоосноос хойш өнөөг хүртэл нэмэгдээгүй /2.5 жил/ байна. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тариф 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 500 төгрөг болсон. Зах зээлд хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ тогтмол өсөж байгаатай холбогдуулан гаалийн байгууллагын албан хаагчдын нийтийн тээврийн унааны үнийн хөнгөлөлтийг нэмэгдүүлэх шаардлагагүй, харин үдийн хоолны үнийн хөнгөлөлтийг өнөөдрийн зах зээлийн үнэ ханштай уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай байгааг судлан үзэж Гаалийн байгууллагын цалингийн сандаа багтаан албан хаагчдын унааны зардлын 500 төгрөгийг хэвээр үлдээж хоолны хөнгөлөлтийг 3.5 дахин буюу сард 473,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж олгохоор тооцооллыг хийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлж	2024.01.01 – 12.31	100

					шийдвэрлүүлэн нийт батлагдсан унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 7,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн шийдвэрлэсэн. 2. Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх: Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дугаар албан даалгаварын төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Төрийн тусгай болон Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 10%-иар нэмэгдүүлж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох” журмын дагуу хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад хөдөөгийн сум /тосгон/-д үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвд үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдлийг сар бүр олгохоор нийт 8,1 тэрбум төгрөгийн нэмэгдлийн тооцоо судалгааг хийж харьяа газар, хороодод санхүүжилтийг хуваарилсан. - Гаалийн байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа нийт төрийн үйлчилгээний албан хаагчдад Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.2-дахь заалт 50 хүртэл хувь болж өөрчлөлт орсонтой холбоотой төрийн үйлчилгээний албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 50 хүртэлх хувиар олгох боломжтой тооцооллыг хийж Захиргааны удирдлагын газар болон Захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулж шийдвэрлүүлсэн. ТҮ1-ТҮ-7 ангиллын албан хаагчдад улиралд 150-200 мянган төгрөгийн урамшуулал нэмэгдсэн.		
--	--	--	--	--	--	--	--

					- Гаалийн байгууллагын ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичиг нарт олгох урамшууллын тооцооллыг хийж Гаалийн ерөнхий газрын даргын тушаалыг гарган 3-4 дүгээр улирлын нийт 140,0 сая төгрөгийн урамшууллыг олгож эхэлсэн. 3. Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж: Гаалийн ерөнхий газар болон түүний харьяа 18 байгууллагаас аймгийн төвд 2 гаалийн газар, хилийн боомтод 14 гаалийн газар, хороонд нийт 1'234 төрийн тусгай албан хаагч Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын төсвийн орлого бүрдүүлэх тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөдөө орон нутаг болон хилийн боомтод ажиллаж буй төрийн тусгай албан хаагчдын эдийн засгийн баталгааг хангах үүднээс албан тушаалын сарын үндсэн цалинг 12 сартай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жилд 1 удаа нийт 19,7 тэрбум төгрөг олгохоор тооцон саналыг Сангийн яаманд хүргүүлснээс 18,8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газрын даргын Б/240, Б/287, Б/362, Б/445, Б/533, Б/584 дугаар тушаалуудын дагуу Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийн 2024 оны 1-11 дүгээр сард эрх нь үүссэн нийт 522 төрийн	
--	--	--	--	--	--	--

					тусгай албан хаагчдад 7,3 тэрбум төгрөгийг хуваарилж олгосон байна. 4.Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагын тэтгэмж: Гаалийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрч гарч буй нийт төрийн тусгай-32, төрийн үйлчилгээний-11 албан хаагчдад 2,2 тэрбум төгрөгийн тэтгэмжийг хуваарилж олгосон. 5. Урамшуулал: Засгийн газрын 2011 оны 345 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчдын 2024 оны 1-4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 2037 албан хаагчдад нийт 7,3 тэрбум төгрөгийг хуваарилж олгосон. 6. Нэг удаагийн тэтгэмж: Нас барсан 8 албан хаагчийн ар гэрт 104.5 сая төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан 80 албан хаагчид 52.8 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, 14 албан хаагчид 17.9 сая төгрөгийн нэг удаагийн шагнал, түлээ нүүрсний хөнгөлөлт 73 албан хаагчид 48.2 сая төгрөгийг тус тус олгосон байна. 7. Нүүлгэлтийн зардал: Захиргааны санаачилгаар шилжилт хөдөлгөөнд хамрагдсан 4 албан хаагчид 2.3 сая төгрөгийн нүүлгэлтийн зардлыг холбогдох баримтыг үндэслэн олгосон байна.		
--	--	--	--	--	--	--	--

					8. Гаалийн улсын байцаагчдын дүрэмт хувцас, дагалдах хэрэгсэл: 2023, 2024 онуудад гаалийн улсын байцаагчдын дүрэмт хувцас, дагалдах хэрэгсэл нийлүүлэх худалдан авах ажиллагаагаар худалдан авсан дүрэмт хувцасны хангалтыг зохион байгуулж нийт 1'091.4 сая төгрөгийн өртөг бүхий нормын хувцсыг давхардсан тоогоор 2'991 гаалийн улсын байцаагчид олгоод байна. Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ын хавсралт-1-д өвлийн ноосон малгай, ороолт гаалийн улсын байцаагчид хангалтаар олгохоор тусгагдсан ч худалдан авалт зохион байгуулагдаж байгаагүй тул тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган худалдан авалтыг зохион байгуулж гаалийн улсын байцаагчдад анх удаа хангалтаар олгох ажлыг зохион байгуулаад байна. 9. Төрийн албаны тухай хууль, Гаалийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах заалтын хүрээнд гаалийн байгууллагын нийт албан хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах ажлыг анх удаа санаачлан худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаа. 10. Гаалийн байгууллагын Ахмадын сангийн журмыг 2023 онд батлан 2024 онд Ахмадын сангийн дансанд 466.0 сая төгрөгийг төвлөрүүлэн ахмад гаальчдын нийгмийн баталгааг дэмжих зорилгоор 196.5 сая төгрөгийг зарцуулаад байна.		
--	--	--	--	--	--	--	--

5	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьсан байдал	Гэрээний биелэлтийн үнэлгээгээр	Гаалийн ерөнхий газрын төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2023 онд 96%-р дүгнүүлсэн.	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг хангуулах зорилгоор нийт хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, тайлан бүртгэл тооцоог сайжруулан төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг хангуулах чиглэлээр болон үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулсан байна.	Гаалийн шинэчлэл, Боомтын сэргэлт төслийн хүрээнд 2019 оноос хойш гаалийн байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалт хийгдэж үндсэн хөрөнгө 142.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах үүднээс дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаа. Үүнд: - Үндсэн хөрөнгийн бүртгэлийг QR кодоор коджуулан бүртгэх ажлыг санаачлан хэрэгжүүлснээр хөрөнгө эзэнтэй болж, ашиглалт сайжирсан, мөн хөрөнгийн тооллыг цахимаар зохион байгуулдаг болсон. - Барилга байгууламж, үндсэн хөрөнгийн ашиглалт, үйл ажиллагааг сайжруулах үүднээс харьяа гаалийн газар, хороодод бусад хил хяналтын байгууллагуудын ашиглаж буй барилга байгууламжийн зай талбай, үндсэн хөрөнгийг “Ашиглалтын гэрээ” байгуулж, хариуцлагжуулан ашиглуулах, албан хаагчидтай “Орон сууц түр эзэмшүүлэх гэрээ” байгуулах, гаалийн байгууллагын бүртгэлд байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн тооллого зохион байгуулах, албан хаагч нартай “Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ” байгуулах, мөн газар, хороод бүтэц орон тоондоо хяналтын тоног төхөөрөмж хариуцсан албан хаагчийг томилуулах саналыг холбогдох нэгжид хүргүүлж шийдвэрлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах үүрэг чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа.	2024.01.01 – 12.31	100
---	---	---------------------------------	--	---	---	--------------------	-----

					Тайлант онд Гаалийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулан хөрөнгө бүртгэлд тусгах, илүүдэлтэй болон ашиглагдахгүй байгаа хөрөнгийг шаардлагатай газар, хороодод шилжүүлэх, харьяа газар, хороодоос ирүүлсэн ашиглалтын шаардлага хангахгүй болсон элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн хөрөнгийн судалгааг тус хурлаар хэлцүүлэн акталж данснаас хасах шийдвэр гаргуулахаар дээд шатны төсөв захирагчаар дамжуулан ТӨБЗГазарт уламжлах зэрэг асуудлыг шийдвэрлэн ажиллаа. (Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 96 хувиар үнэлж ирүүлсэн байна.)		
6	Төсөв, санхүүгийн шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд 100 хувь, иж бүрэн байршуулсан бөгөөд хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл өмнөх онд байхгүй болно.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	ЗГ-ын 2009 оны 143-р тогтоол Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн төсвийн ил тод байдал болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг Гаалийн байгууллагын цахим хуудас болох www.customs.gov.mn , шилэн дансны цахим хуудас болох www.shilendans.gov.mn цахим хуудсанд (байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгөтэй холбоотой байгууллагын даргын шийдвэр гэх мэт мэдээллүүдийг) тухай бүр байршуулан ажилласан. Тайлант хугацаанд хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд	2024.01.01 – 12.31	100

					Шил ажиллагааны https://shilen.gov.mn/ сайтад өөрийн нэгжийн хамааралтай төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллүүдийг улирал бүр шинэчлэн ОНХА-д хүргүүлэн тус сайтад байршуулан ажилласнаар 94 хувиар үнэлэгдсэн байна. Мөн харьяа гаалийн газар, хороодод шилэн дансны мэдээлэлд тогтмол хяналт тавин, хуулийн хугацаанд нь иж бүрэн байршуулах талаар сар бүр дотоод сүлжээ (viber group, facebook chat group)-гээр анхааруулж ажиллан, тайлант оны 5 дугаар сард ХШҮДАГ-тай хамтран Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр болон цаашид анхаарах асуудлын хүрээнд харьяа гаалийн газар, хороодын удирдлага, захиргаа, санхүүгийн албаны албан хаагчдыг хамруулсан цахим сургалтыг зохион байгуулсан.		
7	Улсын орлогын барааны хадгалалт, хамгаалалт, шийдвэрлэлтэд хяналт тавих, гаалийн хяналт шалгалтад ашиглагдах маягт, ломбоны хангалтыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Өмнөх онд харьяа газар, хороодод хураагдаж улсын орлого болгосон бараа тээврийн хэрэгслийг Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол болон бусад холбогдох журмын дагуу тухайн орон нутгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлд хандан шийдвэрлүүлэх талаар тухай бүр зөвлөгөө өгч ажилласнаар шийдвэрлэгдээгүй удсан барааны үлдэгдэлгүй байна. 2. Гаалийн хяналт шалгалтын зорилгоор	Харьяа гаалийн газар, хороодын улсын орлогын барааны хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж, шийдвэрлэгдээгүй удсан барааны үлдэгдэлгүй байна. Тооцоот хуудас, ломбоны бүртгэл хөтлөлт, зарцуулалтад бүртгэлээр хяналт тавьж орлогын тооцоог баталгаажуулсан байна.	Улсын орлогын бараа: <u>Гаалийн байгууллагын хэмжээнд:</u> Гаалийн байгууллагын хэмжээнд улсын орлогын барааны тайланг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн. Эхний үлдэгдэл 2'015.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2'087.0 сая төгрөг байна. 502.5 сая төгрөгийн бараа улсын орлого болгож, 57.6 сая төгрөгийн бараа устгаж, 26.9 сая төгрөгийн бараа худалдан борлуулсан байна. Тухайн орон нутгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлд 342.5 сая төгрөгийн бараа хүлээлгэн өгч шийдвэрлүүлсэн байна. Шинжилгээнд 4.2 сая төгрөгийн бараа хүлээлгэн өгсөн байна. Гаалийн байгууллагын хэмжээнд 6 газар, хороод- /ГЕГ, УБГГ, ЗҮГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ/-д улсын орлого болгосон бараатай байна. БИГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ, ДОГГ-ууд орон нутгийн	2024.01.01 – 12.31	100

			ашиглагддаг нэг удаагийн троссон ломбоны бүртгэлийн CAIS программын лац, ломбоны цэсний хөгжүүлэлтийг 2023 онд газар, хороодод бүрэн нэвтрүүлэн ажиллаж байна.		зөвлөлтэй хамтран ажиллаж улсын орлогын барааны үлдэгдэлгүй болсон байна. Гаалийн байгууллагын хэмжээнд улсын орлогын барааны тайланг 2024 оны 1, 2, 3 дугаар улирлын байдлаар нэгтгэсэн. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар эхний үлдэгдэл 2'087.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2'712.7 сая төгрөг байна. 808.9 сая төгрөгийн бараа улсын орлого болгож, 117.8 сая төгрөгийн бараа устгаж, 50.4 сая төгрөгийн бараа худалдан борлуулсан байна. Шинжилгээнд 3.4 сая төгрөгийн бараа хүлээлгэн өгсөн байна. Тухайн орон нутгийн Албадлагын арга хэмжээ авсантай холбогдуулан хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохиролд нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж шийдвэр гарган биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий зөвлөлийн шийдвэрээр төрийн болон бусад байгууллагад 11.4 сая төгрөгийн бараа шилжүүлсэн байна. Гаалийн байгууллагын хэмжээнд 6 газар, хороод- /ГЕГ, УБГГ, ЗҮГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ/-д улсын орлого болгосон бараатай байна. Нэг удаагийн троссон ломбо: Харьяа гаалийн газар, хороодын албан хүсэлтийг үндэслэн нэг удаагийн троссон улаан ломбо 1'067'300 ширхэг, ногоон ломбо 36'000 ширхэгийн хангалтыг шуурхай зохион байгуулан ажиллалаа. Нэг удаагийн троссон ломбоны хяналтыг сайжруулах үүднээс Хяналт, бүрдүүлэлтийн газар, Мэдээлэл технологийн газартай хамтран Кайс програмын ломбоны цэсний дэд хэсгүүдэд сайжруулалт хөгжүүлэлт хийн	
--	--	--	---	--	--	--

					Улаанбаатар хот дахь гаалийн газарт туршин ажиллаж байна. Үүнд: Улаан болон ногоон ломбоны тус тусдаа цэстэй болгож, ашиглагдсан, төлбөр хийсэн ломбо-/ногдуулалтаас шууд татагдагдсан/-ыг жагсаалтаас хасагдаж үлдэгдэл нь дугаараар харагддаг, эвдрэл гэмтэлтэй ломбоны бүртгэл, ГХБ-ээс ГХБ рүү, ГХБ-ээс ГГХ руу, ГГХ-оос ГЕГ руу бичилт хийдэг болсон. Дээрх хөгжүүлэлтийг улам сайжруулан 2025 оны хагас жилээс бусад газар, хороонд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тооцоот хуудас: Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт"-ын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 08 -ны өдөр нэмэлт, өөрчлөлт орж гаалийн байгууллагын чиг үүргээс амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх хорио цээрийн чиглэлийн гэрчилгээ мэдэгдлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Мал эмнэлгийн ерөнхий газраас тус тус олгохоор шийдвэрлэсэн боловч 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар тухайн хоёр байгууллага нь гэрчилгээ мэдэгдлийг олгох чиг үүргийг хүлээн авах бэлтгэл ажил бүрэн хангагдаагүйгээс гаалийн байгууллага тайлант хугацаанд тасралтгүй хорио цээрийн чиглэлийн гэрчилгээ мэдэгдлийн хэвлэлт болон олголтыг зохион байгуулж, гадаад худалдааны экспорт, импортын гэрчилгээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байгаа болно. 2024 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар гаалийн хяналт шалгалтад шаардлагатай 83.7 мянган төгрөгийн 400		
--	--	--	--	--	---	--	--

					ширхэг шийтгэлийн хуудас маягт-1, маягт-2, 19.1 сая төгрөгийн 34.9 мянган ширхэг экспорт, импортын гэрчилгээ мэдэгдэл шинээр хэвлүүлэн орлогод авсан. ГЕГ-ын дэргэдэх ААҮА болон харьяа гаалийн газар, хороодод гаалийн хорио цээрийн хяналтын экспорт, импортын 40 нэр төрлийн 21.6 сая төгрөгийн гэрчилгээ мэдэгдэл, 140,000 ширхэг 4 сая төгрөгийн зорчигчийн гаалийн мэдүүлгийн хуудас /Монгол, Англи, Орос, Хятад хэлтэй деклариаци /, мөн 971 ширхэг 212.2 мянган төгрөгийн шийтгэлийн хуудас тус бүр олгон байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллалаа. Харьяа гаалийн газар, хороодоос улирал бүр шийтгэлийн хуудас маягт-1, маягт-2 хуудасны тайлан, хорио цээрийн экспорт импортын гэрчилгээний тайланг хүлээн авч шалган, нэгтгэж ажиллаа.		
8	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Суурь үнэлгээ: 4	Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалын хавсралтад заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнан ажилласан байна.	Монгол улсын Засгийн газраас 2019 оноос хойш хэрэгжүүлж буй Гаалийн шинэчлэл төсөл, Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Боомтын сэргэлтийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлэх, боомтын бүтээн байгуулалтын ажлыг түргэвчлүүлж, тоног төхөөрөмжийн угсралтыг зэрэгцүүлж хийхээр үе шаттай зохион байгуулж буй ажлуудын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. Үүнд: Шинэ сэргэлтийн бодлогын нэг дэх хэсэгт заасан Боомтын сэргэлтийн бодлогын 1.1.8 дахь хэсэг: <u>Гаалийн хяналтын шалгалтын рентген тоног төхөөрөмж:</u> Дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд улсын хилээр нэвтэрч буй бараа,	2024.01.01 – 12.31	100

					тээврийн хэрэгслийг шалгах гаалийн хяналт шалгалтын зориулалт бүхий 14 иж бүрдэл "Рентген төхөөрөмж"-ийг ОХУ-ын ИСБ.А компанитай 2019 оны 12 дугаар сард 11 хилийн боомтод суурилуулахаар гэрээ байгуулсан. Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны а/88 тоот тушаалаар Гаалийн хяналт шалгалтын Рентген иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажлуудтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээх авах ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт шалгалтын газрын даргаар ахлуулан байгуулж ажиллуулсан ба Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, удирдлагууд шинээр томилогдсонтой холбоотойгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны а/38 тоот тушаалаар Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт бүрдүүлэлтийн газрын дарга Б.Даваасүрэнгээр ахлуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус гэрээний дагуу эхний тоног төхөөрөмж ОХУ-д үйлдвэрлэгдсэн Шивээхүрэн хилийн боомтод тээвэрлэгдэж, КОВИД-19 цар тахлын нөхцлийн улмаас хилийн боомтуудаар нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг хааснаар суурилуулалт хийх ОХУ-ын инженерийн баг Монгол улсад ирж чадахгүй байснаас суурилуулалтын ажил хойшлогдсон бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 28-нд Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны а/86 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллан уг тоног төхөөрөмжийг хүлээн авч, гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна.	
--	--	--	--	--	--	--

					Гэрээний 2.4.3-т “эхний 1 иж бүрдэл Хяналтын системийг нийлүүлсэн хугацаа болон чанарын шаардлага хангаж байгаа эсэхээс шалтгаалан дараагийн иж бүрдэл Хяналтын системийн захиалга хийгдэнэ” заасны дагуу дараагийн тоног төхөөрөмжийг Боршоо, Замын-Үүд боомтод суурилуулах захиалгыг хийж тус боомтуудад суурилуулалт хийгдэж, гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна. Тоног төхөөрөмжүүдийг хилийн боомтуудад суурилуулахад цацрагийн хамгаалалтын бүсээс шалтгаалан тодорхой орон зайг тооцох шаардлагыг хангах тул АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжсэн Боршоо боомт, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан Замын-Үүд боомтуудын бүтээн байгуулалтын ажлуудтай уялдуулан тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдсэн. ОХУ-ын ИСБ.А компаниас валютын ханшийн өөрчлөлт, тус төхөөрөмжийн программ хангамжийн сайжруулалт хийгдэж байгаа зэргээс тоног төхөөрөмжийн нэг бүрийн үнийг 28,5 хувиар өсгөх саналыг удаа дараа ирүүлж, тус саналыг Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны а/38 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ОХУ-ын ИСБ.А компаний удирдлагуудтай уулзалт хэлэлцээ хийж тоног төхөөрөмжийн нэг бүрийн үнийг 4,6 хувиар буюу 243,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гэрээний үнэд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус гэрээний нэмэгдсэн үнээр буюу тоног төхөөрөмжийн программ өөрчлөлт хийгдсэн тоног төхөөрөмжийн иж бүрдлийг Булган боомтод суурилуулж,	
--	--	--	--	--	--	--

				гаалийн хяналт шалгалтад ашиглаж байна. /ОХУ-ын дайны нөхцөл байдалтай уялдуулан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн Ховд Булган-Баян-өлгий-Цагааннуур боомтоор дамжин өнгөрч буй БНХАУ-аас ОХУ руу транзит ачаанд тавих гаалийн хяналтыг сайжруулах чиглэлийн дагуу тус боомтод уг төхөөрөмжийг суурилуулсан. Мөн БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бүтээн байгуулалт хийгдэж ашиглалтад орж буй Гашуунсухайт хилийн боомтод тус 2 иж бүрдэл тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж Экспорт талд суурилуулсан тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсэг 2024.11.27-нд тус боомтод ажилласан. Импорт талд суурилуулах тоног төхөөрөмжийн суурийн ажил хийгдсэн, тоног төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж байгаа ба 12 дугаар сарын 15-ны дотор багтаан хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй байна. Энэ оны 12 дугаар сарын 10-ны дотор багтаан Замын-Үүд хилийн боомтын ачаа тээврийн хэсгийн Экспорт талд суурилуулах тоног төхөөрөмжийн иж бүрдэл ОХУ-аас тээвэрлэхээр ажиллаж байгаа талаар тус компаниас мэдэгдээд байна. Дээрх суурилуулсан бүх тоног төхөөрөмжүүдэд программ хангамжийн сайжруулалтыг хийлгэж, тус хилийн боомтуудад гаалийн хяналт шалгалтад ашиглаж байгаа ба Гаалийн ерөнхий газрын Шуурхай хяналтын нэгдсэн төвтэй программаар холбон хяналт тавин ажиллаж байна. <u>Гаалийн хяналтын шалгалтын ухаалаг гарц тоног төхөөрөмж:</u>	
--	--	--	--	---	--

					Хилийн боомтуудад ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулснаар боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт сайжирсан. Ухаалаг гарц тоног төхөөрөмж суурилуулсан боомтууд: • Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын экспортын хэсгийн 4, импортын хэсгийн 3 эгнээ замд тус бүрт нь ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг түр суурилуулан 2023.02.17-ны өдрөөс эхлэн өдөртөө хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Тус боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор өнөөдрийн байдлаар нүүрсний гарах хэсэгт хяналтын бүсрүү орох 2, хяналт шалгалтын саравч доор суурилуулсан 3 ухаалаг гарцыг тогтмол ашиглаж байна. Гашуунсухайт боомтод 2024.11.30-ны өдрийн байдлаар нүүрсний терминалын 35, зорчигчийн терминалын 20, зэсийн баяжмалын хэсэгт 4 буюу нийт 59 эгнээ, замд ухаалаг гарцын тоног төхөөрөмж; • Шивээхүрэн боомтын нүүрсний терминалын гарах хэсэгт 7, орох чиглэлийн 3 хэсэгт суурилуулсан ухаалаг гарцын иж бүрдэл төхөөрөмж; • Ханги боомтод 11 байршилд ухаалаг гарцын тоног төхөөрөмж;	
--	--	--	--	--	--	--

					Замын-Үүд боомтын зорчигч тээврийн терминалд 54, ачааны терминалын 39 байршилд, ачааны терминалд 14 байршилд суурилуулсан ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмж тус тус суурилуулан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна. “Алсын хараа-2050”, “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, нүүр тулсан харилцаанаас зайлсхийх, гадаад худалдааг хөнгөвчлөх, гаэдаад худалдаанд оролцогчдод хөнгөн шуурхай үйлчлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн үйл ажиллагаа”-г дэмжин, тус төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг 2024 онд үе шаттайгаар зохион байгуулан ажилалаа.		
9	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Суурь үнэлгээ: 4	Нэгжийн чиг үүрэгт хамааралтай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	СХОГазар нь чиг үүргийнхээ хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган гаалийн байгууллагын урсгал төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилаж, төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнан ажилладаг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Гаалийн байгууллага 2024 онд 26 нээлттэй	2024.01.01 – 12.31	100

					тендер, 34 харьцуулсан тендер, цахим дэлгүүрээс 9 худалдан авалт, 69 бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авахаар төлөвлөн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулан ажиллаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааны А-3 сертификатын хугацаа дууссан болон сертификатгүй албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Гаалийн байгууллага Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Гаалийн ерөнхий газрын даргын албан даалгавар боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: - Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын дарга нарт тодорхой үүрэг даалгавар, чиглэл өгч байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, харьяа газар, хороодод хуваарилсан төсвийг дахин хуваарилах, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах зэрэг	
--	--	--	--	--	--	--

					зохицуулалтыг хийн ажиллаж байна.		
10	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	+	Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд эрсдлийн удирдлагыг хэрэгжүүл ажилласан байна.	Нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж дотоод хяналтыг өдөр тутмын хэвийн үйл ажиллагааны гүйцэтгэлээр тухай бүр хэрэгжүүлсэн. Албан хаагчдын ажлын бүтээмж, цаг ашиглалт, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний тайлагналт, үнэлгээний хуудас зэргээр тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Нэгжийн үйл ажиллагаанд тулгарч буй эрсдэлийг тодорхойлож, эрэмбэлэх, үнэлэх ажлыг зохион байгуулсан.	2024.01.01 – 12.31	100
11	Үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Суурь үнэлгээ: 4.2	Нэгжийн чиг үүргийн хүрээнд өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	Тайлант хугацаанд тус нэгжийн чиг үүрэгт хамааралтай үүрэг даалгавар, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган, тайлагнан ажиллаж байна. Тайлант хугацаанд CERP програмын ҮҮРЭГ ДААЛГАВАР цэсээр Ёс зүйн дэд хорооны хуралдаанаас 1, Онлайн хурлаас 3, Захиргааны зөвлөлийн хуралдаанаас 1, Зөвлөмж 1, Үүрэг даалгавар 8, нийт 14 үүрэг даалгавар өгөгдөж биелэлтийг заасан хугацаанд тайлагнан, холбогдох нэгжээр үнэлүүлэн ажиллаа.	2024.01.01 – 12.31	100
12	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Суурь үнэлгээ: 5	Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт 100 хувь байна.	Тус нэгжийн албан хаагчид ажлын цагийн бүртгэлийг нүүр таниулах системээр бүртгүүлж хэвшсэн бөгөөд албан хаагчид ажлын цагаар гадуур ажиллах үед гаалийн захиргаа, дотоод ажлын системээр нэгжийн даргад хүсэлт илгээн хянуулж, Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжээр баталгаажуулалт хийлгэдэг. Тайлант хугацаанд СХОГ-ын ажлын цаг ашиглалт 100 хувь, чөлөөтэй, тасалсан цагтай албан хаагч байхгүй. 1 албан хаагч 256 цаг буюу 32 өдөр өвчтэй, 3 албан хаагч 2024 оны ээлжийн амралтыг биеэр эдэлж эхэлсэн боловч ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн	2024.01.01 – 12.31	100

					амралтыг дутуу эдэлсэн, 1 албан хаагч ээлжийн амралт эдлээгүй байгаа болно.		
13	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Суурь үнэлгээ: 9	Боомтын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, өөрийн нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан ажилласан байна.	Боомтын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, өөрийн нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд Хөшигийн хөндий ОУНБ дахь хил хяналтын байгууллагуудын нэгдсэн нэг цэгийн үйлчилгээний төв, Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо, Гашуунсухайт боомтуудын бүтээн байгуулалтын барилгын ажил, боомтуудад шинээр суурилуулах гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн байршил, суурилуулалт, Шивээхүрэн, Булган, Хавирга, Баянхошуу, Сүмбэр, Ханги, Бургастай, Цагааннуур, Ханх, Ульхан боомтуудын өргөтгөл шинэчлэлийн нарийвчилсан зураг төслийн ажил, шаардлагатай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн судалгаа, болон хилийн боомтод ажиллах албан хаагчдын амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар судалгаа хийх, санал боловсруулах ажлыг зохион байгуулахад Боомтын хэлтсийг удирдлага арга зүйгээр ханган ажиллаа.	2024.01.01 – 12.31	100
14	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Суурь үнэлгээ: 9	Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2024	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн нэгжийн чиг үүрэгт хамааралтай дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ: Үүнд: - Төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг нээлттэй, ил тод байдлаар Шилэн дансны цахим хуудас, Гаалийн байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Гаалийн ерөнхий газарт 2024 онд санхүүжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу	2024.01.01 – 12.31	100

			оны Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн нэгжид хамааралтай ажлуудыг төлөвлөгөөнд заасан хугцаанд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	одоогийн байдлаар нийт 12 тендерийг зарласан ба Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хорооны гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус гишүүн байхаар үнэлгээний хороог байгуулан ажиллаж байна. - Гаалийн байгууллагын төсөв, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр тайлант хугацаанд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороодын санхүүгийн албан хаагчдыг хамруулсан сургалтыг 2024 оны 1 дүгээр сард зохион байгуулсан. Тус сургалтад Сангийн яам, Төрийн сангийн газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Сангийн яамны төсөл (“Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”) зэрэг газруудаас холбогдох мэргэжилтэн, зөвлөх албан хаагчид хүрэлцэн ирж “Төсвийн төлөвлөлт, анхаарах асуудал”, “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, “Төрийн худалдан авах ажиллагаа төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, анхаарах асуудал”, “ТАЦНС-д тэтгэвэр, тэтгэмжийн тооцоолол хийх” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. Мөн гаалийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас ХШҮДАГазарт ирүүлсэн “Албан шаардлага”-ын хүрээнд тус газартай хамтран ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж биелэлтийг ҮАГазарт хүргүүлэн ажилласан. 2. Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний	
--	--	--	--	---	--

					дагуу тайлант хугацаанд нийт 16 харьяа гаалийн газар, хороодоос 216,0 сая төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зорчих зам, тоног хэрэгсэл болон бусад шаардлагатай зардлын төсвийн төслийг авч Гаалийн байгууллагын 2025 оны урсгал үйл ажиллагааны төсөвт тусгуулахаар нэгтгэсэн.ба 2024 онд санхүүжүүлэх боломжтой зардлуудыг дараах зардлуудыг үе шаттайгаар санхүүжүүлэн ажиллаа. Гаалийн байгууллагаас эхний хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг жигд хүртээмжтэй саадгүй авах нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээний орчныг бий болгох үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: • Замын-Үүд дэх гаалийн газар тэргэнцэртэй иргэн “Гарах”, “Орох” аюулгүй нэвтрэх зам, Автозамын шалган нэвтрүүлэх цогцолборын Зорчигчийн терминалд тэргэнцэртэй иргэн “Гарах”, “Орох” хэсэг рүү нэвтрэх зам, Автозамын шалган нэвтрүүлэх цогцолборын Зорчигчийн терминалын “Гарах”, “Орох” хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөг стандартын дагуу тус тус тохижуулах зардлын санхүүжилт; • Гашуунсухайт гаалийн газар боомтын гадна талаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох, гарах боломжийг хангаж налуу зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүндрэлгүйгээр үйлчлүүлэхэд анхаарч стандарт хангасан ариун цэврийн өрөө, хэлний бэрхшээлтэй иргэдэд зориулж	
--	--	--	--	--	---	--

					үйлчлүүлэгчийн зааланд дижитал самбар тус тус тохижуулж, байршуулах зардлын санхүүжилт; • Шивээхүрэн дэх гаалийн газрын цогцолборын орох, гарах талын хаалганы гадна хөгжлийн бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэдэд зориулан налуу замыг засаж, сайжруулах зардлын санхүүжилт. • Гаалийн ерөнхий газраас: Бүрдүүлэлтийн цахим төв, GAALI.MN гаалийн цахим үйлчилгээний системийн үйл ажиллагааны талаар Сонсголын бэрхшээлтэй иргэд чөлөөтэй ойлгож, мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх үүднээс "Авилгын эрсдлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент"-д дохионы хэлмэрч оручуулгын үйлчилгээний төлбөр, "Гаалийн байгууллагын 2024 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 2 дугаар зорилтын хүрээнд сонсголын бэрхшээлтэй иргэд дурын хэлтэс дээр очиж ойлголцон мэдээлэл, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Гаалийн байгууллагын 1 албан хаагчийг дохионы хэлний анхан болон дунд шатны сургалтад хамруулсан төлбөр, Захиргаа хүний нөөц хариуцсан албан хаагчдын чадавхижуулах сургалтад харааны бэрхшээлтэй багшаар хичээл заасны төлбөр, "Зорчигчийн хилээр нэвтрүүлэх	
--	--	--	--	--	---	--

					журам"-ыг брааль үсгээр хэвлэн нийлүүлэх гэрээний төлбөр зэргийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. 3. Гаалийн байгууллагын 2024 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нэгжийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээнүүдээс дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Албан хаагч бүр өөрт хамаарха ажлын 2023 оны хөтлөгдөж дууссан баримтыг архивын нэгж болгон үдэж, хүлээлгэн өгсөн. Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хот шуудан илгээмжийн гаалийн газрын архивын ерөөний хүртээмж хүрэлцэхгүй, архивын нягтаршуулсан шүүгээ байршуулах зай талбайгүй зэргээс Хөшигийн хөндий дэх нэг цэгийн үйлчилгээний барилга болон Эрэлч нохойн албаны эзэмшиж буй байруудад дээрх газруудын архивыг нүүлгэн байршуулах судалгааг хийж санал боловсруулан ЗУГазарт дотоод зурвасаар хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	2024 онд Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах ажлын хүрээнд дараах сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.Үүнд: - 2024.02.26-ны өдрийн 15.00-19.00 цагт Удирдлагын академийн "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны хуулийн төсөл" хэлэлцүүлэг,	01.01-12.10	100

					- 2024.03.07-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийг танилцуулах “7:4:10” цахим сургалт, - 2024.03.15-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийн хэлэлцүүлэг, - 2024.04.25-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” сэдвийн хүрээнд явагдах “7:4:10” цахим сургалт, - 2024.09.12-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн “Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж, үр дүн” сэдвийн хүрээнд “7:4:10” цахим сургалт, - 2024.10.17-ны өдрийн Төрийн албаны зөвлөлийн “Нийгмийн даатгалын эрх зүйн орчны шинэтгэл, хуулийн хэрэглээ” сэдвийн хүрээнд “7:4:10” цахим сургалт, - 2024 оны 10 дугаар сарын 2-3 ны өдрүүдэд ОХУ-ын Санкт-Перербург хотод рентген тоног төхөөрөмжийн үйлдвэртэй танилцаж, сургалтад хамрагдсан.		
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бие дааж уншиж судалсан байна.	Тайлант хугацаанд шинээр батлагдан гарсан дараах хууль, тогтоол, журмыг тухай бүр бие даан судалж, албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнд: -2023 онд батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль, -“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 2024 оны УИХ-ын 46 дугаар тогтоол, -МУ-ын Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигийн хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”. -ГЕГ-ын даргын тушаалаар баталсан нийт 5 журам, заавар.	01.01-12.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/Д.ДОЛГОРСҮРЭН/

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДОЛГОРСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		64,05

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		12,5
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх		12,5
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			12,5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	14
2	Удирдан зохион байгуулах	14
3	Асуудал шийдвэрлэх	14
4	Манлайлах	14
5	Багаар ажиллах	14,5
6	Харилцаа	14
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	—
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		14,08

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	64,05
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	12,5
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	14,08

Нийт оноо=

(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо

90,6

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Төсвийн шууд захирагч:

..... (Р.Отгонжаргал)
2024.12.19 (огноо)

Нэгжийн дарга:

..... (Д.Долгорсүрэн)
2024.12.20 (огноо)